



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 01 сарын 12 өдөр

Дугаар A/8

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн “Төрийн өмчит зарим үйлдвэрийн газрын талаар авах арга хэмжээний тухай” 317 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 1, 2, 3 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Геологийн судалгаа-шинжилгээний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Ахлагч

Ц.Баяр-Эрдэнэ

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын Төрийн
өмчийн удирдлага,
зохицуулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

С.Шинэ-Од

Үндэсний геологийн албаны Төрийн
захиргааны удирдлагын хэлтсийн
дарга /зөвшилцсөнөөр/

Х.Санчигдорж

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны
Геологийн бодлогын газрын ахлах
шинжээч /зөвшилцсөнөөр/

Б.Сүнжидмаа

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын Төрийн
өмчийн бүртгэл, ашиглалтын
хэлтсийн мэргэжилтэн

С.Пүрэвгарьд

“Геологийн төв лаборатори” төрийн
өмчит үйлдвэрийн газрын ерөнхий
нягтлан бодогч

Б.Содовжамц “Геологийн судалгааны төв” төрийн
өмчийт үйлдвэрийн газрын ерөнхий
нягтлан бодогч

Нарийн бичгийн
дарга


Д.Дариймаа

Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газрын Төрийн
өмчийн удирдлага,
зохицуулалтын хэлтсийн
мэргэжилтэн

2. Захирлын ажлыг 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн дотор энэ
тушаалын хавсралтад заасан удирдамжийн дагуу хүлээлцүүлж, үр дүнг
танилцуулахыг Ажлын хэсэг (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын
12-ны өдрийн үүдлийн тушаалын хавсралт

АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН
АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Ажил хүлээлцүүлэх ажлын хэсэг нь дараах ажлыг хийж гүйцэтгэнэ.

1.“Геологийн судалгаа-шинжилгээний төв” ТӨҮГ-ын тамга, тэмдгийг хүлээлгэн
өгөх,

2.“Геологийн төв лаборатори” ТӨҮГ, “Геологийн судалгааны төв” ТӨҮГ-уудын
дараах баримтуудыг жагсаалт үйлдэн хүлээлгэн өгөх. Үүнд:

- Улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрөл, газрын гэрчилгээ зэрэг бичиг баримт;
- Үндсэн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг /салбар, нэгжээр/ 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар;
- Харилцах банкны хуулга, кассын үлдэгдэл, авлага, өглөгийг 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар;
- Гэрээ хэлэлцээр, холбогдох бусад баримт материал;
- Үндэсний архивт шилжүүлсэн баримт бичиг;
- 2023 онд гаргасан Захирлын тушаал, шийдвэр, албан бичиг;
- Захирлуудын өрөөний хөрөнгө;
- Шаардлагатай гэж үзсэн бусад материал.

3.“Геологийн төв лаборатори” ТӨҮГ, “Геологийн судалгааны төв” ТӨҮГ-уудын тамга тэмдгийг хүчингүй болгох, Улсын бүртгэлээс хасуулах асуудлыг холбогдох хууль журамд нийцүүлэн шийдвэрлэх арга хэмжээ авахыг “Геологийн судалгаа-шинжилгээний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Д.Мөнхбаатарт даалгах.

4.Ажил хүлээлцүүлсэн тайланг 2 хувь боловсруулан 1 хувийг ажил хүлээн авсан тал, 1 хувийг ажлын хэсэг хадгална.

—оОо—